



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2021 оны 02 сарын 04 өдөр

Дугаар 41

Улаанбаатар хот

Биет бус хөрөнгө данснаас хасах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 2, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 2.5.1, 5.1 дэх заалт, Баян-Өлгий аймгийн Засаг даргын 2020 оны А/970 дугаар захирамжийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Ховд их сургуулийн Баян-Өлгий аймаг дахь салбар сургуулийн хөрөнгөд бүртгэлтэй 2,088,000.00 (хоёр сая наян найман мянга) төгрөгийн балансын үнэ бүхий 175 м.кв газар эзэмших эрх /биет бус хөрөнгийг/ нийтийн эзэмшилд шилжүүлсэн тул данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2. Ховд их сургуулийн Баян-Өлгий аймаг дахь салбар сургуулийн захирал Ж.Хиналганд дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Биет бус хөрөнгө хүлээлцэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2021 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

13201032